



БАГАХАНГАЙ ДУУРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/1

Улаанбаатар хот

Г Аюулгүй ажиллагааны зааварчилгааг
шинэчлэх батлах тухай Г

Монгол улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Хөдөлмөрийн Аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалт, байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах журам”-ын хэрэгжилтийг ханган ТУШААХ нь :

1. Эрсдлээс сэргийлэх, аюулгүй орчинд, аюулгүй ажиллагааг мөрдөн ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг хавсралтаар баталсугай.

2. Байгууллагын үйл ажиллагаа эмнэлгийн тусlamж үйлчилгээг үзүүлэхдээ өөрсдийн аюулгүй байдлыг хангаж, эрсдлээс сэргийлж, өдөр тутмын үйл ажиллагаандaa мөрдөж ажиллахыг бүх ажилчдыг үүрэг болгосугай.


3 . Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Хүний нөөц, Дотоод хяналтын ажилтан (Г.Гантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Х.ГАНБАТ



Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын
2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн
АМГИЛГААНЫ ЗААВАРЧИЛГАА тушаалын хавсралт



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Ажилдаа ирэхдээ сайтар амарч, согтууруулах ундаа, мансууруулах бодисын нөлөөнөөс ангид байх.
2. Ажлын халад, хувцас, малгай, бээлийг бүрэн өмсөж, амны хаалтыг тогтмол хэрэглэх.
3. Хөдөлмөр аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцаж гарын үсэг зурах.
4. Байгууллагын өрөө, тасалгааны цэвэрлэгээг тогтмол хийж, агаар сэлгэлтийг тогтмол хийж байх.
5. Өрөөний цэвэрлэгээг хийх явцад тоног төхөөрөмж, эд хөрөнгөд анхаарал болгоомжтой хандах.
6. Ариутгалын бодисын ангилал зориулалтыг зөв хэмжээгээр нь хэрэглэх.
7. Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээг тогтмол хийж, хальтирч унахаас болгоомжлох
8. Хана таазны шороог буулгаж цэвэрлэхдээ шат хэрэглэн аюулгүй ажиллагааг хангасан байх.
9. Өрөөнүүдийн паар болон цонхыг цэвэрлэхдээ гарaa зүсэж гэмтээхээс болгоомжлох.
10. Утас, залгуур, цахилгааны холболттой болгоомжтой харьцаж, хөдөлмөрийн аюулгүй байдэл эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах.
11. Байгууллагаас зохион байгуулж байгаа аливаа сургалт, олон нийтийн арга хэмжээнд бүрэн хамрагдах
12. Цэвэрлэгээний хувин, шүүр, алчуур, тосгуур, шалны мод гэх мэт цэвэрлэгээний багаж хэрэгслийг заасан цэгт эмх цэгцтэй байрлуулна. Алчуурыг зориулалтаар нь ангилан тэмдэгжүүлнэ.
13. Ажилтан бүр ажил үүргээ биелүүлэх явцад аюулгүй ажиллагааны нөхцөл зөрчилдөж хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг, аюултай байдал бий болсон тохиолдолд ажилаа нэн даруй зогсоож, энэ талаар удирдлагадаа яаралтай мэдэгдэнэ.

**ЖОЛООЧ НАРЫН МӨРДӨХ АЮУЛГҮЙ
АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА**

1. Өөрсдийн эзэмшиж байгаа автомашиныг цэвэрхэн нямбай эзэмшиж , бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана.
2. Ажилдаа ирэхдээ сайтар амарч, согтууруулах ундаа, мансууруулах бодисын нөлөөнөөс ангид байх.
3. Автомашины тос, усны түвшин, гэрлэн дохио,толь,тоормос, резин дугуйг, биечлэн шалгах.
4. Автомашины анхааруулах гэрэл, радио станц, галын хор, эмийн сан, зогсолтын тэмдэг, нөөц дугуй, багаж түлхүүр, бусад хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгах
5. Ажлын хувцсыг бүрэн өмсөнө.
6. Цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулан бэлтгэл бэлэн байдлыг хангаж зорчих
7. Автомашины гал унтраагуурыг ашиглах бүрэн чадвартай байх.
8. Аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцан гарын үсэг зурсан байх
9. Албан томилолтоор явахдаа үйлчилгээг хийхдээ хариуцсан мэргэжилтэнд хандаж акт бичүүлж, техникийн комиссоор шийдвэрлүүлэн засвар үйлчилгээг хийлгэнэ.
- 10.Хальтиргаатай, үзэгдэх орчин хязгаарлагдмал үед анхаарал болгоомжтой зорчих.
- 11.Автомашины засвар үйлчилгээг хийхдээ хариуцсан мэргэжилтэнд хандаж акт бичүүлж, техникийн комиссоор шийдвэрлүүлэн засвар үйлчилгээг хийлгэнэ.
- 12.Засвар үйлчилгээг хийх бүрдээ автомашины хувийн хэргийн дэвтэрт заавал тэмдэгжүүлж, гарын үсэг зурах.
- 13.Засвар үйлчилгээ хийхдээ зориулалтын багаж түлхүүрийг хэрэглэхээс гадна гэмтэлтэй багаж хэрэглэхийг хориглоно.

ТОГООЧЫН МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Ажлын байрыг цэвэрлэсэн байх ба шалан дээр ямар нэг бүтээгдэхүүн , тос , ус асгасан тохиолдолд хальтирч унахаас болгоомжлох.
2. Халуун зүйлтэй харьцахдаа заавал гар хамгаалах бээлий өмсөж байх.
3. Ажлын байранд тогооч нь ажлын тусгай хувцас тогтмол өмсөж байх, хальтирахгүй гутал өмсөх.
4. Цахилгаан механик тоног төхөөрөмжүүдийг ашиглахдаа зөвхөн ашиглалтын зааврын дагуу ажиллуулна.
5. Аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцан гарын үсэг зурсан байх
6. Халуун хоол цай зөөвөрлөхдөө хальтирч унах, асгаж түлэгдэхээс болгоомжлох.
7. Цахилгаан тоног төхөөрөмж ашиглахдаа нойтон гараар хүрэхгүй тогонд цохиулахаас болгоомжлох.
8. Хутга заазуур, хурц иртэй зүйлтэй харьцахдаа болгоомжлох.

ЛАБОРАТОРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Ажил эхлэхээс 10 минутын өмнө өрөөний цонхыг онгойлгон агаар сэлгэлтийг тогтмол хийх.
2. Ажлын халад, хувцас, малгай, бээлийг бүрэн өмсөж, амны хаалтыг тогтмол хэрэглэх.
3. Аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцан гарын үсэг зурах.
4. Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажиллах техникийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллах.
5. Тоног төхөөрөмжийг залгаж салгахдаа чийгтэй нойтон гараар харьцахгүй тогонд цохиулахаас болгоомжлох.
6. Ажил дууссаны дараа багаж тоног төхөөрөмжийг унтраан, бүрэн бүтэн байдлыг шалгаж байх.

ХҮЧИЛТӨРӨГЧИЙН БАЛЛОНЫГ
АШИГЛАХ, СОЛИХ ЖУРАМ

1. Хүчилтөрөгчтэй баллонд редукторыг хий гарахааргүй сайн чангалинна. Хүчилтөрөгчтэй баллоныг винтелийг онгойлгоно. Онгойлгоход редукторын эхний манометр баллон дахь хүчилтөрөгчийг зааж өгнө.
2. Редукторын маховикийг онгойлгож, хэрэглэгчид хүчилтөрөгч өгнө. Редукторын хоёрдахь манометр нь хэрэглэж буй хүчилтөрөгчийн даралтыг заана. Өвчтөнд өгөх заалт нь 4-6 л/мин байна.
3. Хүчилтөрөгчийн хэрэглэж байгаа баллоны үлдэгдэл даралт 1MPa болсон байвал баллоныг солино.
4. Баллоныг сууринаас нь салгаж авна.
5. Хоосон болон цэнэгтэй баллоныг тос хүргэхгүй унагааж, доргиохгүй, болгоомжтой тээвэрлэнэ.
6. Хоосон баллоны винтелийг хааж №27 түлхүүрээр редукторыг салгаж авна.
7. Цэнэгтэй баллонд редукторыг хий гарахааргүй сайн чангална.
8. Цэнэгтэй баллоныг сууринд нь хольхиж, холгохгүйгээр бэхэлнэ.
9. Хүчилтөрөгчийн баллонтой ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцаж гарын үсэг зурж байх.
- 10.Хүчилтөрөгчийн өрөөнд орохдоо ил гал гаргахгүй, тамхи татахгүй байхыг анхааруулж байна.
- 11.Хүчилтөрөгч баллон нь тэсрэх аюултай учир болгоомжтой харьцана уу.